



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД 1971-1975 ОНУУДАД ЭДИЙН
ЗАСГИЙН ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ 1970 ОНЫ
АРВАН ХОМРДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР БАЙГУУЛСАН
ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ
П Р О Т О К О Л

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист
Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар,

Монгол, зөвлөлтийн ард түмний хооронд тогтсон ах дүүгийн найрам-
дал, хамтын амиллагааны харилцааг үндэслэн,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас хүсэлт тавьсан-
тай холбогдуулан,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төвийн районы улс ардын аж ахуйг
цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах зорилгоор,

дор дурьдсан зүйлээр тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮҮЛ

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар
зөвлөлтийн холбогдох байгууллагуудаар дамжуулан:

а/Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцыг өргөт-
гөх барилга-угсралтын ажлыг гүйцэтгэх, үүнээс цагт 220 тонн уур
гаргах хүчин чадалтай уурын зуух нэг, 25 мянган квт-ын хүчин ча-
далтай турбин нэгийг 1976 онд ашиглалтанд оруулна;

б/Улаанбаатар хотын дулааны I дүгээр цахилгаан станцыг хааж, ду-
лааны 3 дугаар цахилгаан станцыг 148 мвт хүртэл өргөтгөж ашиглалтанд
оруулахыг бодолцон 1980 он хүртэлх хугацааны хэрэгцээг харгалзан
Улаанбаатар хотын дулааны шугам, мөн 6-10 кв болон 35 кв-ын хүчдлийн



2.

цахилгаан шугам сүлжээний шинэчлэлт, өргөтгөлийн техникийн зураг төслийг хийнэ.

в/ Улаанбаатар хотын дулааны I дүгээр цахилгаан станцын 3 зуух, тэжээл-деаэраторын төхөөрөмжийн засварын ажлыг 1974-1975 оны II улиралд хийхэд техникийн туслалцаа үзүүлнэ;

г/ Налайхын их уурхай болон Шарын голын нүүрсний уурхайн орд газрын нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцээн хийхэд 1974 оноос эхлэн техникийн туслалцаа үзүүлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэ Протоколын I дүгээр зүйлийн дагуу зөвлөлтийн байгууллагуудаас 1974 онд хийж гүйцэтгэх ажилд шаардагдах I,4 сая рублийн зардлыг Монголын Тал Монгол-Зөвлөлтийн 1970 оны арван хоёрдугаар сарын 28-ны өдрийн Хэлэлцээрээр аж үйлдвэр, их барилгыг хөгжүүлэх, геологи хайгуулын ажлыг явуулахад зориулан олгосон 100 хүртэл сая рублийн зээлийн хөрөнгийн хэсгээс төлнө.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Дээр дурьдсан ажлыг зөвлөлтийн байгууллагаас хийхтэй холбогдон 1975 онд гарах зардлыг төлөхөд зориулан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт 17 сая рублийн нэмэгдэл зээлийг жилийн 2 хувийн хүүтэйгээр 1976 оны нэгдүгээр сарын I-нээс эхлэн 15 жилийн хугацаанд жил бүр тэнцүү хэсгээр төлөхөөр олгов.

Энэ Протоколын 2 дугаар зүйлийн дагуу төлөгдөх зардлыг энэ зүйлд заасан зээлийн хөрөнгөөс эргүүлэн тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэ Протоколд заагдаагүй бусад зүйлийг Монгол-Зөвлөлтийн 1970 оны арван хоёрдугаар сарын 28-ны өдрийн Хэлэлцээрийн заалтын дагуу гүйцэтгэнэ.



3.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэ Протокол гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Үүнийг 1974 оны долдугаар сарын " 14 "-ны өдөр Москва хотноо тус бүр монгол, орос хэл дээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх хувь адил хүчин төгөлдөр болно.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ЭРХ ОЛГОШООР

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙ-
РАМДАХ ХОЛБООТ УЛСЫН ЗАС-
ГИЙН ГАЗРЫН ЭРХ ОЛГОШООР